

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
2.9	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12.	Шилэн дансны мэдээлэл	11
2.13.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5	Аудит явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гол асуудал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТЫН IV ЦАХИЛГААН
СТАНЦЫН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ Э.МӨНДӨР
ТАНАА

2020.02.20 № 06/541
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн нэгжийн санхүүгийн тайланд:


Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газраас төслийн санхүүгийн ажилтны 2019 оны хөлсөөр ажиллах гэрээг сунгаагүй, 31,303.8 мянган төгрөгийн цалинг тушаал, шийдвэргүй олгосон зөрчил нь санхүүгийн тайлангийн эрх үүрэг, тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Э.Мөндөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагналыг сайжруулах, авлага, өглөгийн дансдын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан тайлагнах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төслийн удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төслийн зохицуулагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор Н.Дэлгэрмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 596 дугаар бүхий албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол улсын Засгийн газар болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх MON-P10 хөтөлбөрийг 2014 оноос 2018 онд хэрэгжүүлэхээр 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн гэрээг байгуулсан.

Дээрх зээлийн хэлэлцээр болон Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдэх” журмыг үндэслэн 2014 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Сангийн яам, Улаанбаатар хотын IV цахилгаан станц ТӨХК-ийн хооронд 4.2 сая иентэй тэнцэх хэмжээний санхүүжилтийн дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулан MON-P10 хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Төслийн зорилго:

Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үндсэн тоноглолууд болох уурын турбин ба зуухыг шинээр суурилуулах замаар цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, техникийн найдвартай ажиллагааг ханган Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах юм.

Төслийн зорилт, хүрэх үр дүн:

Төслийн гүйцэтгэгч шалгаруулах олон улсын нээлттэй тендерт 2 багц ажлыг санал болгосон бөгөөд эхний багц ажилд Японы Yokogawa компани шалгарсан бол хоёр дахь багц ажилд Японы MHPS болон Монголын MCS компаний хамтарсан консерциум шалгараад байна.

Нэгдүгээр багц ажлын хүрээнд “Дулааны цахилгаан станц 4” ТӨХК-ийн уурын турбины 1-6-д тохируулгын механик гидравлик системийг цахилгаан гидравлик системээр өөрчлөн шинэчилж, турбинуудын хяналт удирдлагын системийг компьютерын хяналт удирдлагын системд шилжүүлэх ажлыг Японы Yokogawa компани хийх бол, багц 2 ажлын хүрээнд нийт 8 зууханд үнс үлээлгийн 192 аппарат суурилуулж, 5-8 дугаар зуухны 16 тээрэмд 64 ширхэг бул тавгийг шинэчлэх ажлыг Японы MHPS болон Монголын MCS компани хийж гүйцэтгэх юм.

Үүний үр дүнд Улаанбаатар хотын “Дулааны цахилгаан станц 4” ТӨХК-ийн уурын турбины тохируулгаас хамаарсан зогсолт 100 хувь буурах бөгөөд цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлтийн хэмжээ 2019 он гэхэд 18 хувиар нэмэгдэнэ. Түүнчлэн нүүрсний зарцуулалтын хэмжээ 8 хувиар буурч, хүлэмжийн хийг ихээхэн хэмжээгээр багасгах юм. Ингэснээр тоноглолын горим үйл ажиллагаа тогтворжиж, аваар саатал гарах нөхцөл буурна. Цаашлаад ажилчдын ажиллах нөхцөл сайжирч, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ.

Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Төслийн нэгж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3-д заасан дарааллын дагуу нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй, хураангуй бүртгэлийг хөтлөөгүй, тайлагналыг Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааварт бүрэн нийцүүлээгүй байна.

Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэл бүрэн хөтлөөгүй, Ексел хэрэглээний программаар боловсруулсан мэдээллийг ашигладаг байна.

Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн дотоод хяналтын эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны үйл ажиллагааны урсгал зардлын батлагдсан төсвийг сонгож, эрсдлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 340,000.0 мянган төгрөгөөс тооцон 6,800.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6,107.4 мянган төгрөгөөр тооцсон нь төсвийн гүйцэтгэлийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,596.9 мянган төгрөгөөр буюу 29.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	2,196.7	2,196.7
Үндсэн хөрөнгө	3,835.4	3,235.6	(599.8)
Нийт хөрөнгө	3,835.4	5,432.3	1,596.9
Өр төлбөр	-	6,443.8	6,443.8
Эздийн өмч	-	-	-
Хуримтлагдсан үр дүн	3,835.4	(1,011.5)	(4,846.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,835.4	5,432.3	1,596.9

Авлага дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд ажиллагсдад олгосон үр дүнгийн урамшуулалт цалингаас нийгмийн даатгалын шимтгэл 1,263.7 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татвар 933.0 мянган төгрөг нийт 2,196.7 мянган төгрөгийг залруулан бүртгэсэн тул ажиллагсдаас авах авлага нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь тайлангийн хугацаанд байгуулсан элэгдлийн зардлаар хуримтлагдсан элэгдлийн дүн нэмэгдсэн тул цэвэр хөрөнгийн дүн буурахад нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь үр дүнгийн урамшуулалт цалингаас ажиллагсдаас суутгаагүй болон ажил олгогчийн зардлыг тооцоолон бүртгээгүй 2,640.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, цалингаас илүү суутгасан 73.3 мянган төгрөгийн татварыг ажиллагсдад өгөх өглөг, ажиллагсдын үр дүнгийн урамшуулалт цалингаас суутгаагүй татвар 933.0 мянган төгрөг, цалингаас суутган тооцсон боловч төсөвт дутуу төвлөрүүлсэн 2,797.5 мянган төгрөг нийт 3,730.5 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын өглөгүүдийг залруулан бүртгэсэн тул нэмэгдсэн байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүжилт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Зээлийн санхүүжилт	7,105,222.6	4,727,876.0	(2,377,346.6)	66.5
Улсын төсвийн санхүүжилт	340,000.0	302,497.2	(37,502.8)	89.0
Нийт дүн	7,445,222.6	5,030,373.2	(2,414,849.4)	67.6

Тайлант онд 7,445,222.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 340,000.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 7,105,222.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 340,000.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 7,105,222.6 мянган төгрөгийг Япон улсын олон улсын байгууллага Жайкагийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал төсвийн зардлын нийт гүйцэтгэл 302,497.2 мянган төгрөг буюу 89.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант онд төслийн үйл ажиллагаа дуусч байгаа учир 2 инженерийн хөлсөөр ажиллах гэрээг хагас жилээр байгуулсан нь цалингийн зардалд хэмнэлт үүссэн байна. Төсөл эхэлснээс хойш хугацаанд төслийн ажилтнуудад үр дүнгийн урамшуулалт цалин олгоогүй байсан талаар Төслийн удирдах хорооны 2019 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн хурлаар хэлэлцэн, дээрх хэмнэсэн зардлаас 11,010.2 мянган төгрөгийн урамшуулалт цалинг олгохоор шийдвэрлэж, Сангийн яамнаас төсвийг зөвшөөрсөн байна.

Тайлант оны бичиг хэргийн зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 43,427.4 мянган төгрөгөөр илүү төлөвлөж, 32,368.0 мянган төгрөгийн хэмнэлттэй зарцуулсан байна.

Урсгал зардлын батлагдсан төсвөөс нийт дүнгээр 37,502.8 мянган төгрөгийн хэмнэлттэй зарцуулсныг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Японы олон улсын байгууллага Жайкагийн зээлийн санхүүжилтийн хөрөнгөөр төсөл арга хэмжээнд 7,105,222.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 4,727,876.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Санхүүжүүлэгч нь зээлийн санхүүжилтээс гүйцэтгэгч нарт шууд төлбөр хийдэг бөгөөд, Сангийн яам тусгай дансаар зээлийн ашиглалтыг хянаж, бүртгэдэг.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 9 эрсдэл тодорхойлж, нийт 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 54,682.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 19,805.7 мянган төгрөгийн алдааг залруулж үүнээс ажиллагсдаас суутган аваагүй татвар шимтгэл 3,573.0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 31,303.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, нягтлан бодох бүртгэл, тайлагналыг боловсронгуй болгох, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 асуудлаар зөвлөмж өглөө. Үүнд:

1. Тайлант онд Сангийн яамны 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 10/572 албан бичгээр төслийн ажилтнуудын цалин шинэчлэн тогтоож ирүүлсэн сүлжээг мөрдсөн байна. Ажилтнуудын 2018 оны хөлсөөр ажиллах гэрээнд 2019 онд ажиллуулах сунгалтыг хийсэн боловч Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газраас санхүүгийн ажилтны гэрээг сунгаагүй, 31,303.8 мянган төгрөгийн цалинг тушаал, шийдвэргүй олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан журмын 10.1.21-д "төслийн зохицуулагч, санхүүгийн ажилтан, худалдан авалтын мэргэжилтний хөлсөөр

ажиллах гэрээг сунгах, цуцлахдаа сангийн яамнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр шийдвэрлэх" гэсэн заалттай нийцээгүй, эрх үүрэг, тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Төслийн ажилтнуудад олгосон үр дүнгийн урамшууллын цалингаас 1,263.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй, ажил олгогчийн 12.5 хувийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,376.3 мянган төгрөг нийт 2,640.0 мянган төгрөгийг нийгмийн даатгалын байгууллагад тайлагнаагүй, төлөөгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-д "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", 17.1.2-д "шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх" гэсэн хуулийн заалттай нийцэхгүй, эрх үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олгосон урамшуулалт цалингаас суутган тооцох 1,263.7 мянган төгрөгийг ажилтнуудаас авах авлага, ажил олгогчийн зардал 1,376.3 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд бүртгэн нийт 2,640.0 мянган төгрөгийг нийгмийн даатгалын байгууллагад өгөх өглөгөөр залруулан тайлагнаж, нийгмийн даатгалын нөхөн тайлан гаргаж баталгаажуулах тул акт тогтоохоор шийдвэрлэв.

3. Дээрх урамшуулалт цалингаас 933.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг тооцож суутгаагүй, татварын тайланд тайлагнаагүй, төсөвт төлөөгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.3.1-д "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого"-д албан татвар ногдоно, 17.1.1-т "энэ хуулийн 11.1.1, 11.1.6-д заасан орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр" татвар ногдуулна гэсэн заалтуудтай нийцэхгүй, эрх үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урамшуулалт цалингаас суутгаагүй 933.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг төсөвт төвлөрүүлэхээр акт тогтоон, ажилтнуудаас авах авлага, хувь хүний орлогын албан татварын өглөгөөр бүртгэн залруулан тайлагнахаар шийдвэрлэв.

4. Ажиллагсдын цалингаас суутган тооцсон 2,870.8 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын өглөгөөр, ажиллагсдын цалингаас илүү суутган тооцсон 73.3 мянган төгрөгийн татварыг авлагаар бүртгээгүйгээс үүссэн 2,797.5 мянган төгрөгийн татварын өглөгийг тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, эрх үүрэг, тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажиллагсдаас илүү суутгасан 73.3 мянган төгрөгийн татварыг татварын байгууллагаас авах авлага, ажиллагсдад өгөх өглөгөөр, дутуу төлсөн хувь хүний орлогын албан татварын 2,870.8 мянган төгрөгийг тайлант оны зардал, хувь хүний орлогын албан татварын өглөгөөр бүртгэн залруулан тайлагнахаар шийдвэрлэв.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төслийн үйл ажиллагаа дуусч тоног төхөөрөмжийн системийн үйл ажиллагаанд туршилт хийхээр хүлээгдэж байна. Зээлийн санхүүжилтээр хийгдэх зөвлөх үйлчилгээний гэрээний хэрэгжилт хугацаанаасаа хоцорч байгаа талаар төслийн удирдах хорооны хурлын тэмдэглэлүүдэд дурьдагдсан байна. Иймд зээлийн санхүүжилтийн сүүлчийн төлбөр тооцоо, гэрээний гүйцэтгэлийг дараагийн аудитаар нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 6 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 459.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь биелсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хязгаарлалттай дүгнэлт:

Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн 31,303.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил нь бидний тооцсон 6,107.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурьдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Төслийн 2019 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх оны мэдээлэлтэй зэрэгцүүлэн тайлагнаагүй, зөвхөн тайлант оны эцсийн үлдэгдлийг тайлагнасан байна. Санхүүгийн тайланд дагалдах нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй, хураангуй журнал бүртгэл, гүйлгээ баланс бэлтгээгүй байна.

1.2 Эрсдэл:

Санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлан ангилал болон ойлгомжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байх

1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-д заасан “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 14.1 "Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана" гэснийг хэрэгжүүлэх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Мөнгөн хөрөнгийн журналаар мөнгөний зарлага болон үлдэгдлээ хянадаг.

2. Авлага, өглөгийн тооцооны бүртгэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт

Үр дүнгийн урамшууллын цалингаас 1,263.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй, ажил олгогчийн 12.5 хувийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,376.3 мянган төгрөгийг тооцоолон бүртгээгүй нийт 2,640.0 мянган төгрөгийг нийгмийн даатгалын байгууллагад, мөн 933.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг тооцож суутгаагүй, татварын байгууллагад тус тус тайлагнаагүй, төлөөгүй байна. Ажиллагсдын цалингаас 73.3 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг илүү суутган тооцож, татварын байгууллагад илүү төлсөн дүнг авлага, өглөгөөр бүртгээгүй, тайланд тусгаагүй. Суутган тооцсон боловч төсөвт төлөөгүй 2,870.8 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг өглөгөөр бүртгээгүй, тайлагнаагүй.

Тайлангийн хугацаанд үүссэн 6,443.8 мянган төгрөгийн авлага, өглөгийн тооцоог Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсний дагуу тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

2.2 Эрсдэл

Татвар, нийгмийн даатгалын хуулиар татвар шимтгэлийг дутуу ногдуулсан дүнд торгууль, алданги хүлээх.

2.3 Өгсөн зөвлөмж

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангуудыг нөхөн гаргаж тайлагнах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Тайлангаа залруулж, нөхөн тайлан гаргана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	-	-
33	АВЛАГА	-	2,196,698.23
33500	Бусад авлага	-	2,196,698.23
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	2,196,698.23
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
39200	Биет хөрөнгө	3,835,433.42	3,235,633.42
39205	Машин, тоног төхөөрөмж	5,998,000.00	5,998,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,162,566.58)	(2,762,366.58)
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,835,433.42	3,235,633.42
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,835,433.42	5,432,331.65
41	Богино хугацаат өр төлбөр	-	-
41360	Бусад өглөг	-	2,639,992.58
41362	Ажиллагсадын өглөг	-	73,339.30
41363	Татварын өглөг	-	3,730,518.22
41364	Нийгмийн даатгалын өглөг	-	2,639,992.58
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	6,443,850.10
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	6,443,850.10
	ЭЗНИЙ ӨМЧ	-	-
51200	Хуримтлагдсан үр дүн	3,835,433.42	(1,011,518.45)
51210	Өмнөх үеийн үр дүн	4,435,233.42	3,835,433.42
51220	Тайлант үеийн үр дүн	(599,800.00)	(4,846,951.87)
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	3,835,433.42	(1,011,518.45)
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	3,835,433.42	5,432,331.65

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	41,019,258,262.89	5,067,876,014.91
13	ТАТААС САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	41,019,258,262.89	5,067,876,014.91
1310	Улсын төсвийн санхүүжилт	338,352,159.70	340,000,000.00
120	Зээлийн санхүүжилтийн орлого	40,680,906,103.19	4,727,876,014.91
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	338,951,959.70	344,846,951.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	338,951,959.70	344,846,951.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	330,878,721.00	288,163,230.97
210101	Цалин	295,461,647.00	245,249,753.11
210102	Нэмэгдэл цалин	-	11,010,246.89
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	35,417,074.00	31,903,230.97
2104	Хангамж, бараа материалын зардал	7,473,438.70	18,581,111.63
210401	Бичиг хэргийн зардал	3,616,155.00	14,675,500.00
210402	Тээвэр, шатахууны зардал	2,709,560.00	2,909,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн зардал	1,147,723.70	995,761.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	599,800.00	599,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	599,800.00	599,800.00
213	Урсгал шилжүүлэг	-	37,502,809.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	37,502,809.27
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	40,680,306,303.19	4,723,029,063.04
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	40,680,906,103.19	4,727,876,014.91
225009	Дамжуулан зээлдүүлэх зээл	40,680,906,103.19	4,727,876,014.91
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(599,800.00)	(4,846,951.87)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	Татаас санхүүжилтийн орлого	41,019,258,262.89	5,067,876,014.91
131001	Улсын төсвийн санхүүжилт	338,352,159.70	340,000,000.00
120	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	40,680,906,103.19	4,727,876,014.91
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	41,019,258,262.89	5,067,876,014.91
2101	Ажиллагсадтай холбоотой зардал	330,878,721.00	283,916,079.10
210101	Цалин хөлсний зардал	295,461,647.00	253,389,129.00
2102	НДШ-ийн зардал	35,417,074.00	30,526,950.10
2104	Бараа үйлчилгээний бусад зардал	7,473,438.70	18,581,111.63
210401	Бичиг хэрэг	3,616,155.00	14,675,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,709,560.00	2,909,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,147,723.70	995,761.63
2108	Хөтөлбөр арга хэмжээний зардал	819,449,101.90	560,518,881.16
210801	Гадаад зөвлөхийн зардал	819,449,101.90	560,518,881.16
213	Урсгал шилжүүлэг	-	37,502,809.27
213302	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	37,502,809.27
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	1,157,801,261.60	900,518,881.16
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II)	39,861,457,001.29	4,167,357,133.75
221001	Их засвар	-	-
222001	Тоног төхөөрөмж	39,861,457,001.29	4,167,357,133.75
22	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (IV)	39,861,457,001.29	4,167,357,133.75
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(V)=(IV)-(V)	(39,861,457,001.29)	(4,167,357,133.75)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	4,435,233.42	4,435,233.42
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			-
3	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		(599,800.00)	(599,800.00)
4	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	3,835,433.42	3,835,433.42
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-	-
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		-	-
7	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			-
8	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			-
9	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		(4,846,951.87)	(4,846,951.87)
10	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл		(1,011,518.45)	(1,011,518.45)

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,445,222,600.00	5,030,373,205.64	2,414,849,394.36	67.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,276,222,600.00	863,016,071.89	2,413,206,528.11	26.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,276,222,600.00	863,016,071.89	2,413,206,528.11	26.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал			-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,032,500.00	30,526,950.10	1,505,549.90	95.3
2104	Хангамж, бараа материалын зардал	51,707,500.00	18,581,111.63	33,126,388.37	35.9
210401	Бичиг хэрэг	47,043,500.00	14,675,500.00	32,368,000.00	31.2
210402	Тээвэр, шатахуун	2,909,900.00	2,909,850.00	50.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	1,754,100.00	995,761.63	758,338.37	56.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,192,482,600.00	813,908,010.16	2,378,574,589.84	25.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,192,482,600.00	813,908,010.16	2,378,574,589.84	25.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,169,000,000.00	4,167,357,133.75	1,642,866.25	100.0
222001	Тоног төхөөрөмж	4,169,000,000.00	4,167,357,133.75	1,642,866.25	100.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,445,222,600.00	5,030,373,205.64	2,414,849,394.36	67.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	340,000,000.00	302,497,190.73	37,502,809.27	89.0
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,105,222,600.00	4,727,876,014.91	2,377,346,585.09	66.5
	Тохируулсан орлогын дүн	-	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-		
	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
	АЖИЛЛАГСАДЫН ТОО		8		
	Удирдах ажилтан		1		
	Гүйцэтгэх ажилтан		5		
	Үйлчлэх ажилтан		2		
	Гэрээт ажилтан				

5 Аудит явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2020/109/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл			Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	З	4	5	8	9
1	Тайлант онд Сангийн яамны 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 10/572 албан бичгээр төслийн ажилтнуудын цалин шинэчлэн тогтоож ирүүлсэн сүлжээг мөрдсөн байна. Ажилтнуудын 2018 оны хөлсөөр ажиллах гэрээнд 2019 онд ажиллуулах сунгалтыг хийсэн боловч санхүүгийн ажилтны гэрээг сунгаагүй, 31,303.8 мянган төгрөгийн цалинг тушаал, шийдвэргүй олгосон байна.	31,303.8	Албан шаардлага хүргүүлэх	Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан	Э.Мөндөр О.Ундрах
2	Үр дүнгийн урамшуулалын цалингаас 1,263.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй, ажил олгогчийн 12.5 хувийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,376.3 мянган төгрөг нийт 2,640.0 мянган төгрөгийг тооцон нийгмийн даатгалын байгууллагад тайлагнаагүй, төлөөгүй байна.	2,640.0	НДШ-ийн тооцоог НД-ын байгууллагад төлөхөөр акт тогтоох	Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан	Э.Мөндөр О.Ундрах
3	Үр дүнгийн урамшууллын цалингаас 933.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг тооцож суутгаагүй, татварын тайланд тайлагнаагүй, төсөвт төлөөгүй байна.	933.0	ХХОАТ-ыг төсөвт төвлөрүүлэхээр акт тогтоох	Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан	Э.Мөндөр О.Ундрах
Нийт дүн		34,876.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 02 дугаар сарын 28

№ 02/24

Улаанбаатар хот

С.Н.Т. 2020/103/СТА-ТХХ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төслийн ажилтнуудад олгосон үр дүнгийн урамшууллын цалингаас 1,263.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй, ажил олгогчийн 12.5 хувийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,376.3 мянган төгрөг нийт 2,640.0 мянган төгрөгийг тооцоогүй, нийгмийн даатгалын байгууллагад тайлагнаагүй, төлөөгүй.
2. Мөн дээрх урамшуулалт цалингаас 933.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг тооцож суутгаагүй, татварын тайланд тайлагнаагүй, төсөвт төлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3 дахь заалт, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", 17 дугаар зүйлийн 17.1.2 "шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх";

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого"-д албан татвар ногдоно, 17.1.1-т "энэ хуулийн 11.1.1, 11.1.6-д заасан орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр" татвар ногдуулна гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна" гэж заасны дагуу хариуцаж албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

1. Урамшуулалт цалингийн ажилтнуудаас суутгаагүй 1,263,711.71 төгрөг, ажил олгогчийн 12.5 хувийн зардал 1,376,280.87 төгрөг нийт 2,639,992.58 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг тооцоолон Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн Төрийн сан банкны 100900011608 тоот дансанд 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх, нөхөн тайлан гаргаж тушаах;
2. Мөн дээрх урамшуулалт цалингийн ажилтнуудаас суутгаагүй 932,986.52 төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг нөхөн тооцож Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 100900000601 тоот дансанд 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх;
3. Актын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн нэгжийн төсвийн шууд захирагч, төслийн зохицуулагч Э.Мөндөр, төслийн санхүүгийн ажилтан О.Ундрах нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
АУДИТОР
Н.ДЭЛГЭРМАА

ЗӨВШӨӨРСӨН:
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ,
Э.МӨНДӨР
ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН АЖИЛТАН
О.УНДРАХ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 02 дугаар сарын 28

№ 02/30

Улаанбаатар хот

СБГ 2020/109/СТА-ТХН

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заалтын дагуу Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн нэгжийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Сангийн яамны 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 10/572 албан бичгээр төслийн ажилтнуудын цалин шинэчлэн тогтоож ирүүлсэн сүлжээг мөрдсөн байна. Ажилтнуудын 2018 оны хөлсөөр ажиллах гэрээнд 2019 онд ажиллуулах сунгалтыг хийсэн боловч Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газраас санхүүгийн ажилтны гэрээг сунгаагүй, 31,303.8 мянган төгрөгийн цалинг тушаал, шийдвэргүй олгосон байна.

Энэ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, мөрдүүлнэ", Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан журмын 10.1.21 "төслийн зохицуулагч, санхүүгийн ажилтан, худалдан авалтын мэргэжилтний хөлсөөр ажиллах гэрээг сунгах, цуцлахдаа Сангийн яамнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр шийдвэрлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...", гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан журмын 10.1.21 "төслийн зохицуулагч, санхүүгийн ажилтан, худалдан авалтын мэргэжилтний хөлсөөр ажиллах гэрээг сунгах, цуцлахдаа Сангийн яамнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр шийдвэрлэх" заалтыг ажилдаа хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг таслан зогсоох, цаашид давтан гаргахгүй ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн нэгжийн төсвийн шууд захирагч, төслийн зохицуулагч Э.Мөндөр, төслийн санхүүгийн ажилтан О.Ундрах нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
 АУДИТОР *[Signature]*
 Ц.НАРАНЧИМЭГ
 ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
 АУДИТОР *[Signature]*
 Н.ДЭЛГЭРМАА

ЗӨВШӨӨРСӨН:
 ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ,
 Э.МӨНДӨР
 ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН АЖИЛТАН
 О.УНДРАХ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Khoree\Alban Shaardlaa\2020\02\21\SAGR Docx

001080053

